



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 10 сарын 07 өдөр

Дугаар 59

Төрийн ордон, Улаанбаатар хот

### Түр хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэг, Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 31 дүгээр тогтоолын 1 дэх заалтад заасан Түр хорооны бүрэлдэхүүнийг доор дурдсанаар шинэчлэн баталсугай:

#### Түр хорооны дарга:

Б.Баттөмөр Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга

#### Түр хорооны гишүүд:

Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга

Б.Саранчимэг Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга

Г.Мөнхцэцэг Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга

Э.Батшугар Улсын Их Хурлын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга

П.Анужин Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга

Ж.Мөнхбат Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга

Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын

хорооны дарга

Т.Энхтүвшин

Улсын Их Хурлын гишүүн, Үйлдвэржилтийн  
бодлогын байнгын хорооны дарга

Л.Мөнхбаатар

Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын  
хорооны дарга

Ц.Цэрэнпунцаг

Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын  
хорооны дарга

Б.Бейсен

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь  
Ардчилсан намын бүлгийн төлөөлөл

С.Ганбаатар

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь  
“Та бидний эвсэл”-ийн төлөөлөл

Т.Доржханд

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь  
“Зөв хүн электорат эвсэл”-ийн төлөөлөл

2.Энэ тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж  
мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР